



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/135

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", 29.1.6 "а", 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1 Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 11 дүгээр хурал, засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймагт коронавируст халдвар (ковид 19)-ын халдварын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан шаардлагатай үед ашиглах нэг удаагийн түргэвчилсэн оношлуур, нэг удаагийн үзлэгийн бээлий авах зардал болон сорьц тээвэрлэсэн шатахууны зардалд 10.700.000 (Арван сая долоон зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 10.700.000 (Арван сая долоон зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг дарга ерөнхий дансанд батлагдсан гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Нармандах)-д зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан төсвийн зарцуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцүүлэн зохион байгуулж, бүрдүүлсэн нөөц хэрэгслийг шаардлагатай цэгүүдэд хяналттай хуваарилан үр дүнтэй зарцуулж, тайлагнахыг Эрүүл мэндийн газрын дарга (М.Үүрийнбаяр)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР